

# МОНГОЛЧУУДЫН ЦАГААЧЛАЛЫН ШИНЭ ХЭЛБЭР - ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГОД НӨЛӨӨЛЖ БАЙГАА НЬ

Д.Сэрдарам

Дэд профессор, Доктор (Ph.D)  
ШУТИС-ийн Бизнесийн удирдлага,  
Хүмүүнлэгийн сургууль

**М**онголын орчин үеийн түүхэн дэх хамгийн том, нийгэмд өвөрмөц нөлөө үзүүлсэн шилжилт хөдөлгөөний түүх 20 гаруй жилийн өмнөөс эхэлжээ. Орчин үеийн олон улсын харилцаа, даяарчлагдсан нийгмийн хөгжил Монгол улс төдийгүй дэлхий дахиныг шилжилт хөдөлгөөний хэмнэлд оруулсан байна. Хүн төрөлхтний энэхүү эрчимтэй шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх нөлөөлөл янз бүр байсан. Хүйтэн дайны үед дайн самуун, бүс нутгийн дайн тулаан хүн төрөлхтний шилжилт хөдөлгөөнд хамгийн их нөлөө үзүүлж байсан бол орчин үед техник технологи, соёл иргэншлүүдийн нөлөөлөл цоо шинэ шилжилт хөдөлгөөнүүдийг улам хурдацтай, өргөн хүрээнд хийлгэх болжээ. “Өнөөдөр Монгол улс өөрөө нүүдэл дунд байна. Хөдөө орон нутгаас Хот суурин руу, хот суурингаас гадаад руу чиглэсэн хүмүүсийн урсгал өдөр ирэх тутам өсөн нэмэгдэж байна”<sup>1</sup> 20 жилийн өмнө казах үндэстний шилжин суурьших хөдөлгөөнөөр эхэлсэн Монголчуудын нүүдэл “ганзагын наймаачдын 1, 2, 3-р үеийн хөдөлгөөн, БНСУ дахь хөдөлмөрийн цагаачлал, 1990-ээд оны эхэн үед болсон төв, суурин газраас хөдөө рүү хийсэн нүүдэл, дараалсан зудны дараа 2000 оны эхэн үед болсон хөдөөнөөс хот руу тус тус хийсэн шилжилт хөдөлгөөн, 2000 оны дунд үед гарсан боловсролын, одоо анхаарал татаад байгаа эмнэлэгийн үйлчилгээний шилжилт хөдөлгөөнүүд нь бүгд Монголчуудын шилжилт хөдөлгөөн буюу миграцийн түүхэнд сонирхолтой судлагдахуун болж байгаа шинэ сэдэв юм. Үүнд Монголын төр засаг тодорхой бодлого боловсруулж зохицуулалт хийхгүй, зарим тохиолдолд дээрх төрлийн шилжилт хөдөлгөөний хэлбэрүүдийг өөрийн сонирхлын зөрчилдөө ашигласаар маш олон сөрөг үр дагавруудыг бий болгоход дөхөм үзүүлж байгаа нь харамсалтай. Монголчуудын энэ шилжилт хөдөлгөөний олон хэлбэрийн давалгаа нь эерэг, сөрөг 2 талтай бөгөөд бид эерэг талыг нь үл ашиглан, сөрөг талыг үл тоомсорлон, зарим тохиолдолд явцуу эрх ашигаараа түүнийг дэвэргэж байгаа нь харамсалтай төдийгүй энэ байдал цаашид даамжирвал бэрхшээлтэй зүйл олон гарч болохыг БНСУ дахь Монгол иргэдийн эмнэлэгийн үйлчилгээний цагаачлалын асуудал дээр жишээ авч илтгэхийг хичээлээ.

<sup>1</sup> Б. Алтанхүү “Шинэ үеийн нүүдэл суудал: Тулгамдсан асуудал” илтгэл. 2006 он. Англи улс.

**Нэг. Цагаачлал уу? Шилжилт хөдөлгөөн үү? - түүний нэг төрөл болох Эмнэлэгийн үйлчилгээний цагаачлалын тухай ойлголт.**

Глобальчлалын эрин үеийн дэлхийн дахины онго төрх маш хурдацтай оорчлогдож байна. Тухайлбал, 250 жилийн өмнө дэлхийн хамгийн баян ба ядуу орны 1 хүнд оногдох баялагийн 5:1 байсан ба Европын хүн амыг Хятадтай харьцуулахад 2:1 гэж байсан бол өнөөдөр баян Швейцарь, ядуу Мозамбикийн хоорондын ялгаа нь 450:1 болсон байна.<sup>2</sup> Хөгжингүй орнууд нь хоцрогдсон, буурай улсуудаа хөгжүүлэх нь тэдний цааш хөгжих чухал нөхцөл гэдгийг ойлгож зарим тохиолдолд улс төрийн засаглалыг нь ч үл харгалзан буурай орнуудад санхүү, эд материалын туслалцаа дэмжлэг үзүүлэхийн хамт шинэ техник, мэдээллийн технологи нэвтрүүлж байна. Зарим хүмүүс энэ бодлогыг ядуу буурай улс орнуудаас жил ирэх тутам нэмэгдэж байгаа гадаадын цагаачдын нүүдлийг багасгах, дотоодын зах зээл, хүн амаа хамгаалсан бодлогын нэг хэсэг гэж үздэг бол миний хувьд Даяарчлал хурд, Экологийн сүйрэл бидний өмнө нийтлэг тулгамдсан асуудлуудыг бий болгож, түүнийг хамтдаа шийдвэрлэхийн тулд хөгжингүй орнууд туслалцаагаа харамгүй хуваалцаж байна гэж арай өөдрөг сэтгэлгээгээр харж байна.

Хоол хүнс, Үйлдвэрлэл, Боловсрол, Эрүүл мэнд ямар ч улсын Үндэсний аюулгүй байдлын чухал сэдэв байдаг. Манай улсын нийгмийн асуудлуудын нэг эмнэлэгийн үйлчилгээ, түүний хоцрогдол, эмнэлэгийн үйлчилгээнээс урган гарч байгаа сөрөг зүйлүүдийг шийдвэрлэж чадахгүй удааширснаас шилжилт хөдөлгөөн буюу миграцийн шинэ хэлбэр 2000 оны эхэн үеэс гарч ирлээ.

Энэ асуудлыг хөндөхөөс өмнө Миграц гэдэг нэр томъёоны талаар товч саналаа бичье. Энэ үгийг шилжих хөдөлгөөн, тархан суух, цагаачлал, нүүдэл гэх мэтээр орчуулдаг. Хамгийн өргөн утгаар хэрэглэгддэг нь Цагаач, Цагаачлал юм. Энэ үг монгол хэлэнд доромж утгаар хэрэглэгддэг бөгөөд гарлын хувьд цагаан идээний боловсруулалт буюу Цагаа гэдэг үгнээс үүсэлтэй. “Итгэлтний цагаа зохижээ”<sup>3</sup> Харин хаа нэгэнтээ хүний нутагт ганц нэгээрээ буюу өрхөөрөө тэнүүчилж, мал сүрэгтэй чинээлэг айл бараадан ажлаас нь нугалж, аяга тарга, айраг сүүтэй (цагаа) залгаж буйгаа цагаач хэмээн гоочилж нэрлэсээр ирсэн.<sup>4</sup> Орчин үеийн хамгийн тулгамдсан энэ асуудлын нэр томъёог судлаач, эрдэмтэд нэг мөр шийдэх зайлшгүй шаардлагатай бөгөөд цагаачлал, цагаач гэдэг монгол үгийг хэрэглэх нь ач холбогдолтой юм.

Дэлхийн хүн амын тодорхой хэсэг хувь нь энэ бүлэгт орсон, дийлэнх хувь “цагаач” болоход бэлэн буюу мөрөөдлийн ойлголт болж хувирчээ. Дэлхий даяар цунами мэт хүчтэй давалгайлж байгаа хүн амын шилжилт хөдөлгөөний

<sup>2</sup> НҮБ-ын Хүний хөгжлийн тайлан илтгэл 2015 он.

<sup>3</sup> Ч. Лодойдамба “Тунгалаг Тамир” УБ. 1983, 56-р тал

<sup>4</sup> <http://shbaatar.blogspot.com/2008/10/vc.html>

түрэлтэнд нь Монгол улс орж насанд хүрсэн хүн амын бараг 15 хувь нь гадаадад гарсан, хүн амын 80 илүү хувь нь ямар нэг шилжилт хөдөлгөөн хийсэн гэсэн албан бус тоо баримт байдаг. Энэ талаар судалгааны болон бодлого хэрэгжүүлэгч, боловсруулагч байгуулагууд ямар нэг албан ёсны тоо баримт одоогоор гаргаж ирээгүй байна. Мөн гаднаас хүн амын шилжилт хөдөлгөөний түрлэг Монголд орж ирж байна. *“Манай улсад 2015 оны 9-р сарын байдлаар 105 орны 38 мянга гаруй гадаадын иргэн ажиллаж, амьдарч байна. Гадаадын иргэн харьяатын асуудал эрхлэх газрын мэдээлснээр оны эхний 9 сард 19 орны 2367 гадаад иргэнийг албадан гаргажээ. Харин өнгөрсөн сард гадаадын 23 орны 327 иргэнд захиргааны арга хэмжээ авсан нь өмнөх оны мөн үеэс 34.8 хувиар буурч, 60.2 сая төгрөгийн мөнгөн торгууль ногдуулсан байна. Зөрчлийн дийлэнх нь буюу 36 хувь нь визийн хугацаа хэтэрсэн. Ийм зөрчлийн улмаас 51 аж ахуйн нэгж, байгууллагад 61.2 сая төгрөгийн мөнгөн торгууль ногдуулж, нийт дүнгээр 38.3 сая төгрөгийг улсын төсөвт оруулсан байна”* гэсэн мэдээллээр манай цагаачлалын бодлого, хийсэн ажлын мэдээлэл хязгаарлагдаж байна.<sup>5</sup>

Дэлхийн хэмжээний олон улсын хэд хэдэн байгууллага цагаачлалтай холбоотой асуудлуудыг голлон анхаарч олон улсын гэрээ хэлэлцээр, конвенци боловсруулан улс орнуудыг нэгдүүлэхийг хичээдэг ч улс орон бүр одоогоор цагаачлалын асуудал дээрээ өөрийн улсын эрх ашгийг тэргүүн зэрэгт тавьж байна. Дэлхийн хөдөлмөрийн байгууллага, Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага нь цагаачдыг Байнга оршин суухаар явагсад, Гэрээт ажилчид, Мэргэжилтнүүд, Хууль бус цагаачид, Улс төрийн орогнол хайгчид буюу Дүрвэгсэд гэж 5 ангилсан нь тэдгээртэй холбоотой асуудлыг нийтлэгээр авч үзэхэд ач холбогдолтой<sup>6</sup> болсон байна. Монгол улсад дүрвэгсдээс бусад цагаачлалын хэлбэр байгаа бөгөөд гадаадад ажиллаж амьдарч байгаа Монголчуудын тоо хүн амынхаа 15 хувьд хүрсэн, тэдний ихэнх нь хөдөлмөрийн нас, нийгмийн хамгийн идэвхтэй хэсэгт ордог. Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагын гаргасан дараах тоо баримтаар нотолж болно. 200 сая шилжин суурьшигчид нь дэлхийн нийт хүн амын 3 хувийг эзэлж байгаа бөгөөд тэдний 20-30 сая нь хууль бус “хөдөлмөрийн цагаач иргэд” байна гэсэн судалгаа байдаг. 20-64 насны хүмүүсийг хөдөлмөрийн цагаач иргэд гэж авч үздэг бөгөөд тэдний тоог тодорхойлоход хэцүү боловч нийт цагаачдын 10-15 хувийг эзэлж байна. Тэдний 49,6 хувь нь эмэгтэйчүүд байна. 2015 онд Хөдөлмөрийн цагаачлал хийсэн иргэд 337 тэрбум ам.долларын мөнгөн гуйвуулга хийсний 251 тэрбум нь улс орныхоо эдийн засагт маш чухал үүрэг гүйцэтгэж байгааг Дэлхийн банк онцлон тэмдэглэж байсан. Хөдөлмөрийн цагаачлал нь нийт хөдөлмөрийн зах зээлийн 3 хувийг эзэлдэг бөгөөд нийт хөдөлмөрийн цагаачдын 40 хувь нь үйлдвэрлэл,

<sup>5</sup> “Нийгмийн толь” өдөр тутмын сонин. 2012.10.02-ны дугаар

<sup>6</sup> Б. Алтанхүү “Шинэ үеийн нүүдэл суудал: Тулгамдсан асуудал” илтгэл. 2006 он. Англи улс

хар ажилд, 50 хувь нь үйлчилгээний салбарт хөдөлмөр эрхэлдэг байна. Тэд Европ, Ази, хойд Америк гэсэн дэлхийн ондор хөгжилтэй 3 том бүс нутагт ажилладагаас Азид хөдөлмөрийн цагаачдын улам ихэснэ гэж судлаачид үздэг. Манай улсын хувьд шилжин суурьшигчдын дийлэнх хувийг нь хөдөлмөрийн цагаачлалын ангилалд хамааруулж ойлгож болно. Тэдний ихэнх нь БНСУ-д ажиллаж амьдардаг бөгөөд БНСУ нь Монголчуудын хуримтлалын санхүүгийн ихэнх хувийг боловсролын болон эмнэлэгийн үйлчилгээний салбараар эргүүлэн авч байна.

*Эмнэлэг, Боловсролын үйлчилгээ авч байгаа хүмүүсийг яагаад заавал миграцийн ангилалд оруулж байгаа юм бэ? Энэ Аялал жуулчлалын нэг төрөл байж болохгүй юм уу? гэдэг асуудал судлаачдын дунд маргаантай байдаг. Миграцийг хүмүүс сайн дураар хийдэг боловч наад захын хэрэгцээ, шаардлагыг хангаж чадах үйлчилгээ авч чадахгүй байгаа, эдийн засаг, нийгмийн сэтгэл зүйн дарамттай хийж байгаа шилжин нүүх хөдөлгөөн явагдаж байгаа учир үүнийг Миграцийн хөдөлгөөнд хамруулахаас өөр аргагүйг судалгаа хийх явцад бүрэн ойлгосон билээ.*

#### **Хоёр. БНСУ дахь Монголчууд.**

Гадаад дахь Монголчуудын дийлэнх хувь нь БНСУ-д хөдөлмөрийн цагаачлалын хэлбэрээр амьдарч байна. 26-хан жилийн түүхтэй 2 улсын дипломат харилцаа хурдацтай хөгжсөнд улс төр, дипломат харилцааны айлчлалаас илүү 2 улсын иргэдийн харилцан хийсэн шилжилт хөдөлгөөн чухал үүрэг гүйцэтгэсэн байна. Мөн түүхэн уламжлалт харилцаа, нийтлэг хэв шинж, геополитикийн нэг язгуур эрх ашиг зэрэг олон нийтлэг талууд манай 2 улсыг ойр дөт байлгадаг. Монголчууд 1988 онд БНСУ-д анх удаа зорчиж байсан бол одоо тэнд “Солонгосын Монголчууд” гэсэн амьдралын орчин бүрэлджээ<sup>7</sup>.

1970-аад оны сүүл үед Солонгос улсын гэнэтийн үсрэнгүй хөгжил дэлхийн хөдөлмөрийн цагаачлалын чиглэлийг энэ улс руу хандуулжээ. 20-30 жилийн өмнөхөн өөрсдөө хөдөлмөрийн цагаачлал, хүүхэд гадаадад үрчлүүлэхээрээ<sup>8</sup> дэлхийд дээгүүр байр эзэлж байсан энэ улс цагаачлалын зөөлөн бодлого баримталж хямд ажиллах хүч ашиглаж чадснаараа өнөөдрийн хөгжилд хүрснийг судлаачид онцлон хэлдэг.

Цагаачлал нь Хүний эрхийн хамгийн чухал асуудлын нэг болохоор хүчээр бус бодлогоор зохицуулагдах нийгмийн эмзэг асуудлуудын нэг юм. Орчин үеийн нийгмийн харилцаа гүнзгийрэх тусам цагаачлалын хэлбэр, төрөл олон янз

<sup>7</sup> 15 жилийн турш тасралтгүйгээр БНСУ-д ажиллаж амьдарч байгаа гэр бүл, хувь хүмүүс цөөнгүй байгаа нь тус улс “Гадаад дахь Монголчуудын” нэгэн орчин болсныг харуулж болно.

<sup>8</sup> Дайны дараах хүнд жилүүд буюу 1956-1970 онд 1 сая гаруй балчир насны хүүхдүүдээ гадаад үрчлүүлжээ

болж хүрээгээ цааш улам тэлж байна. Жишээлбэл, БНСУ-д цагаачлалын 37 төрлийн виз байдаг бол Канадад 40, АНУ-д 32 төрлийн цагаачлалын хэлбэр байдаг. Орчин үед улс төр, эдийн засаг, нийгмийн олон салбарт цагаачлалын олон хэлбэр өргөжиж, цаг уурын цагаачлал, эрүүл мэндийн шилжин суурьшилт, боловсролын цагаачлал зэрэг шинэ төрлүүд нэмэгдэж байна. Цагаачлах нь хүний эрх чөлөө бол цагаачдаа ашиглах нь, түүнийг хянаж, зөв зохицуулалттай байх нь Төр засгийн бодлого учраас шинэ хэлбэрээр өргөжин төрөлжиж буй цагаачлал буюу шилжилт хөдөлгөөний шинэ хэлбэрүүд нь манай улсын эдийн засаг, нийгэм, улс төр, соёлын харилцаанд том нөлөө үзүүлэхүйц асуудал болж байгаа тул судлаачдын анхаарлыг өөрийн эрхгүй татаж байна.

Монголчуудын шилжилт хөдөлгөөний хамгийн их хүлээн авагч орон сүүлийн 20 шахам жилд БНСУ дангаараа байлаа. Жилд дунджаар 56.000 – 60.000 монголчууд дангаараа БНСУ-д зорчиж байна. Сүүлийн жилүүдэд 2 улсын боловсролын харилцаа өргөжиж, БНСУ-ын их дээд сургуулиудад манай залуучууд ихээр суралцах боллоо. Түүнээс гадна эмнэлэгийн салбарын үйлчилгээ авдаг Монголчуудын тоо ихсэж байна. Эмнэлэгийн үйлчилгээ авдаг хүмүүсийг яагаад эмнэлэгийн үйлчилгээний цагаачлалд оруулж байгаа вэ? Үүнд:

1. Энэ төрлийн аялал жуулчлалын ангилалд оруулж болохгүй. Зугаа цэнгэл, үйлчилгээний төрлөөс илүү хүний эрхийн наад захын шаардлагыг хангаагүй учраас энэ төрлийн аялал цагаачлалын ангилалд орно.
2. Эдийн засгийн хүчин зүйл. 2008 оноос өссөн Монгол улсын Эдийн засгийн өсөлтийн дүнд гарсан хуримтлал нь дотоодын үйлчилгээ, нийгэм хамгааллын салбар дахь доголдлын улмаас боловсрол, эрүүл мэндийн салбарт мөнгөний урсгал эрчимтэй явагдсан.
3. Эмнэлгийн салбарт тооны хувьд өөрчлөлт гарсан боловч чанарын доройтол маш их гарсан. Монгол улс дахь эрүүл мэндийн наад захын үйлчилгээний доголдол нь нийгмийн сэтгэл зүйд сөрөгөөр нөлөөлөх болсон. Ямар нэг дуулиантай хэрэг явдлын дараа гадаадад эмнэлэгийн үйлчилгээ авагчдын тоо ихэсдэг.
4. Гадаад орнууд ялангуяа Тайланд, БНХАУ, Энэтхэг, Солонгос, Сингапур зэрэг улс эмнэлэгийн үйлчилгээний маркетингаа сайжруулж Монголчуудыг зорилгот зах зээлээ болгож олон төрлийн үйлчилгээ хийдэг болсон.

## Гадаадад эмнэлэгийн үйлчилгээ авагчид



Монголчууд эдийн засгийн тодорхой хэмжээний хуримтлалынхаа дийлэнх хэсгийг боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээнд гадагшаа урсгаж байна. 90 жилийн түүхтэй, дэлхийд үнэлэгдэж байсан Анагаах ухааны салбарын хөгжил харьцангуй өндөр манай улс Гадаадад эмчлүүлэхэд дэмжлэг үзүүлэх өвчний жагсаалтыг жил бүр гаргадаг. 2013 онд 27 төрлийн өвчнийг гадаадад эмчлүүлэхэд дэмжлэг үзүүлэх буюу дотооддоо эмчлэх боломжгүй гэж Төрөөс албан ёсоор хүлээн зөвшөөрсөн байна. Эрүүл мэндийн яаманд жил бүр 250-300 гадаадад эмчлүүлэх эмчилгээний зардал хүссэн өргөдөл ирдэг бөгөөд 40 орчим хувь нь Яам болон НД-ийн газраас дэмжлэг авсан байна. <sup>9</sup>


Монголчуудын дийлэнх нь үндсэн 6 оронд эмнэлэгийн үйлчилгээ авдаг. Яг хэдэн улсад, хэдэн хүн, хэдий хэмжээний мөнгөөр эмнэлэгийн үйлчилгээ авдаг нь тодорхойгүй. Дунджаар жил бүр 140 тэрбум төгрөгийг манай иргэд гадаадын эмнэлгүүдэд төлдөг багцаа судалгаа <sup>10</sup> гаргажээ. Сүүлийн үед анагаах ухааны үйлчилгээгээрээ дэлхийд тэргүүлж байгаа БНСУ-ын эмнэлгүүдээр олон улсын иргэд үйлчилгээ авч байна. БНСУ-ын ДНБ-ийн 10 орчим хувь, аялал жуулчлалаар олсон орлогын 45 хувь нь эмнэлэгийн үйлчилгээний салбараас олсон орлого байна. БНСУ жил бүр энэ салбарын үйлчилгээнийхээ өсөлтөнд анхаарлаа хандуулж Их сургуулиудын эмнэлэг болон хувийн тусгай салбарын эмнэлэгийн үйлчилгээний стандарт, тэдэнд тавих шаардлага, үйлчилгээ, хүний нөөцийн сургалтанд онцгой анхаарлаа хандуулж байна. 2014 онд БНСУ-ын Ёнсей эмнэлэгээр үйлчлүүлсэн гадаадын иргэд.

Нийгмийн, Эрүүл мэндийн даатгалын тогтолцоо хамгийн сайн хөгжсөн, Эрүүл мэндийн үйлчилгээ сайтай АНУ-аас 871 хүн ирж үйлчлүүлсэнтэй Монгол улсын иргэд тэнцүү байна. Энэ тоо бол зөвхөн улсын чанартай болон Их сургуулийн харьяа том эмнэлгүүдээр үйлчлүүлсэн иргэдийн тоо.

<sup>9</sup> Монгол Улсын Гадаад Харилцааны Яамны ХМА-аас мэдээлэл. 2015 оны 2 сар <http://www.president.mn/content/11506>

<sup>10</sup> Мөн тэнд

2014-2015 онд БНСУ-ын хамгийн том, өндөр өртөгтэй Ёнсей эмнэлгээр үйлчлүүлэгчид нь тухайн улс орны эмнэлэгийн үйлчилгээний дүр төрхийг тодорхойлдог. Ёнсей эмнэлгээр үйлчлүүлэгчдийн 24 хувь нь Монголчууд байна. Энэ тоо өмнөх үеийнхээсээ 2, 7 хувиар өссөн байна. Тогтмол өсөх хандлага ажиглагдаж байна.




Жилд дундажаар 20.000-30.000 орчим Монголчууд гадаадад эмнэлгийн үйлчилгээ авдаг бөгөөд энэ тоо жил бүр нэмэгдэж байгаа гэсэн баримжаа судалгааг Олон улсын байгууллагууд баримталдаг. Нийт 6 улсад голчлон эмнэлгийн үйлчилгээ авахаар зорчдог бөгөөд үйлчлүүлэгч нарыг хамгийн их хүлээн авдаг улс нь БНСУ, Хятад байна. БНСУ нь 1995 оноос Монгол Улсын хөдөлмөрийн цагаачдыг хүлээн авч эхэлсэн бөгөөд хамгийн оргил үедээ буюу 2005 онд нийтдээ 48.000 гаруй иргэдийг хүлээн авч ажиллуулж Монголчуудын хуримтлалд эерэг нөлөө үзүүлжээ. Гэхдээ Монголчуудын диаспора БНСУ-д бүрэлдэн тогтоогүй юм. Үүний дараа 2008 оны үеэс БНСУ дахь Монголчуудын цагаачлалын 2 дахь давалгаа Боловсролын цагаачлалаар эхэлжээ. Одоо энэ тоо 4.700 орчимд хүрж Гадаад оюутны тоогоороо манай улс Хятадын дараа, мөн Япон улстай зэрэгцэж иржээ.

Гадаадад эмнэлгийн үйлчилгээ авагчдыг ямар улс орнуудад зорчиж байгааг судалгаагаар харуулбал дараах үзүүлэлт гарч байна.



БНСУ-д эмнэлгийн үйлчилгээ авахаар зорчиж байгаа иргэдийн дийлэнх нь эмэгтэйчүүд байгаа бөгөөд 2012 онд нийт 8.347 иргэд БНСУ-д эмнэлгийн үйлчилгээ авсан бол<sup>11</sup> 2015 онд 12.450 болж өссөн байна



Энэ тоо жил ирэх бүр нэмэгдэж байна. БНСУ-ын албан ёсны мэдээгээр 2013 онд манай улсын 55.198 иргэн БНСУ-д эмчилгээ, оношлогоо хийлгэсэн ба үүнээс 12.034 иргэн эмчилгээний визээр ирж нийт 30 гаруй сая ам.долларыг эмчилгээ, оношлогоонд зарцуулсан<sup>12</sup> бол одоо энэ дүнг судалсан, нарийвчлал хийсэн ямар нэг олон улсын болон ТББ-ууд байдаггүй.

Сөүл хотноо дундаж эмнэлэгээс эхлээд, бүх төрлийн нарийн шинжилгээ хнйж, эмчилдэг өндөр зэрэглэлийн сайн эмнэлэг олон бий. Эмнэлгийн чанарыг дагаад тэдгээрийн үйлчилгээний төлбөр 2 дахин зөрүүтэй. Ердийн эмнэлэгт 360 000 воноор хийдэг бүх биеийн багцын шинжилгээг сайн чанарын эмнэлгүүдэд 800 000 орчим воноор хийлгэнэ.<sup>13</sup> Эмнэлгийн үйлчилгээний төрөл нь жил бүр ихсэж энгийн үйлчилгээ авахдаа хүртэл Монголчууд БНСУ-д зорчиж байна. БНСУ 2008 оноос Монголчуудын “Ентертаймент улс” болж байна. Чөлөөт цаг, Шоппинг, Боловсрол, Эрүүл мэндийн үйлчилгээг БНСУ-аас авч байна. БНСУ-ын бодлого энэ үзэгдлийг дэмжиж, БНСУ-ын том эмнэлгүүдэд үйлчилгээ авахаар мөнгөө төлсөн бол Визний олон талын хөнгөлөлт үзүүлдэг болсон төдийгүй БНСУ-ын эмнэлгүүд хажуудаа Монгол оюутнуудыг ажиллуулдаг үйлчилгээний төв байгуулж манай улсаас үйлчлүүлэгчдийг олноор татаж байна. Солонгосын улсын чанартай 6 том эмнэлэгт Монголчуудад үйлчилдэг тусгай хэсэг ажилладаг бөгөөд эмнэлэгийн үйлчилгээ үзүүлэх газрыг зуучилдаг 12 төв ажиллаж, 120 гаруй эмнэлэгийн мэргэжлийн орчуулагчид ажиллаж


<sup>11</sup> БНСУ-ын Цагаачлалын албаны 2015 оны статистик мэдээлэл. <http://www.immigration.go.kr/>

<sup>12</sup> БНСУ-ын Цагаачлалын албаны 2014 оны статистик мэдээлэл. <http://www.immigration.go.kr/>

<sup>13</sup> <http://bolormaa.niitlech.mn/content/5198.shtml> “Бүтэн биений шинжилгээ” гэдэг нь... нийтлэл. Л. Болормаа

байсан<sup>14</sup> бол одоо 48 албан ёсны байгууллага болж өргөжсөн байна. БНСУ-ын Эрүүл мэндийн яам, Корё болон Ёнсей их сургуулийн дэргэд “Эмнэлэгийн үйлчилгээний төв”-д ажиллах Солонгос хэлний орчуулагчдыг бэлтгэдэг сургалт явуулж сертификатжуулан үйлчилгээний соёл, хариуцлагатай байдлыг тусгай журамд оруулсан байдаг.

БНСУ зөвхөн Монголчуудад төдийгүй Хятад, Япон, Вьетнамын үйлчлүүлэгч нартаа туслах ийм төвүүдийг байгуулсан байна. Солонгос Аялал жуулчлалын салбартаа зөвхөн жуулчдыг татахаас гадна шинэ гэр бүлийн бал сарын аялал, боловсролын болон эмнэлэгийн үйлчилгээ, тусгай зорилтот аялал жуулчлалын салбарт хөрөнгө татах санхүүгийн тусгай бодлого явуулж байгаагийн илрэл юм. Ялангуяа Боловсрол, Эрүүл мэндийн салбарт хөгжиж байгаа болон буурай орнуудаас үйлчлүүлэгч нарыг татахад онцгой анхаарлаа хандуулж байгаагийн илрэл нь дараах үзүүлэлтээс харагдаж байна.



Энэ тоо цаашид улам нэмэгдэх нь ойлгомжтой.

### Дүгнэлт

Монгол улсын эдийн засаг тэлж чаддаггүй нь дотоодын зах зээл бага, үйлдвэрлэл, төслүүдийг санхүүжүүлэх хөрөнгө босгох бололцоогүй, дотоодын ажиллах хүчин хомс гэх мэтээр олон хүчин зүйлээр тайлбарладаг боловч шинэ нөхцөл байдал биднийг арай өөр өнцөгөөс харахыг шаардаж байна. Их баялаг бидний сэтгэх уураг тархийг мансууруулж байгаа шиг бид зөвхөн зэс зэрэг уул уурхайн бүтээгдэхүүний үнийн өсөлт бууралтаар эдийн засгийн хөгжил, өрсөлдөх чадвараа тодорхойлж байгаа нь туйлын харамсалтай. Энэ байдал даамжирвал бидний эдийн засгийн өсөлтийн дүнд бий болж байгаа жаахан хуримтлал маань нийгмийн үйлчилгээний салбарын уналт, доройтлоос болж

<sup>14</sup> БНСУ-ын Цагаачлалын албаны 2012 болон 2015 оны статистик мэдээлэл. <http://www.immigration.go.kr/>

гадагшаа урсаж байгаа нь ойлгомжтой. Энэ мөнгийг эдийн засгийн хөрсөндөө шингээх хэрэгцээ, зах зээлийн боломж манай улсад байна. Үүнд:

- Эмнэлэгийн үйлчилгээнд зарцуулж байгаа мөнгийг нутагшуулах. Хамгийн сайн чанарыг шинжилгээний төв байгуулах дундаж зардал нь 69 тэрбум ₮, 140 тэрбум төгрөг нь орчин үеийн стандартад нийцсэн 2 том эмнэлэг шинээр байгуулах зардалтай тэнцэнэ.<sup>15</sup> Ийм хэмжээний хөрөнгө оруулалтыг Үндэсний компаниуд оруулаад эхэлж байна. Эдийн засгийн энэ боломжийг Төр, Засгийн газар мэдрэмжтэй харж бодлогоор дэмжих хэрэгтэй.
- Эрүүл мэндийн шинэчлэлийн хөтөлбөр, ЗГ-ын бусад бодлогод Эмнэлэгийн цагаачлалын асуудлыг хөндөөгүй буюу эмчилж чадах, хөгжүүлэх бололцоо байгаа Эрүүл мэндийн салбараа өрсөлдөх чадваргүй болгож байна. Боловсон хүчний болон мэргэжилдээ хандах ажлын хариуцлагагүй байгаагаас өөрийн улсын анагаах ухаандаа итгэл алдарч байна. Энэ уршигтай байдлыг Эрүүл мэндийн салбар даруй таслан зогсоох шаардлагатай.
- Brain gain буюу Гадаадын эмнэлэг, үйлчилгээг бус үндсэн боловсон хүчиндээ тулгуурлан нутагшуулах уламжлалт бодлого алдагдсан байна.
- Нийгмийн даатгалын үнэ цэнийг дээшлүүлэх хэрэгтэй. Монголчууд гадаадад эмчлүүлэх зардлаа нийгмийн болон эрүүл мэндийн даатгалаар шийдвэрлэх бололцоо байхгүй, элдэв төрлийн хандив, туслалцаа олон нийт болон байгууллага, хувь хүмүүсээс авах хөдөлгөөн өрнүүлдэг хөөрхийлөлтэй үзэгдэл газар авчээ. Эрүүл мэндийн даатгалын тогтолцоог хувийн хэвшилд шилжүүлэхээс гадна Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, УИХ-ын гишүүд зэрэг төрийн өндөр албан тушаалтнуудыг зөвхөн улсдаа эмнэлэгийн хяналтад байж, эмчлүүлэх үүрэгтэй гэсэн хуулийн заалтыг бусад улсуудын жишгээр тогтоох нь хамгийн хэрэгтэй санагддаг.

#### Ашигласан бүтээл:

1. Томас Фридман “Дэлхий бөөрөнхий биш” УБ. 2007.
2. Immigration bulletin 2013. Seoul. 20146
3. “세계는 지금 어디로 가고 있는가” Солонгос хэлээр.
4. [www.hss.edu.mn/history home page](http://www.hss.edu.mn/history_home_page)
5. Френсис Фукаяма “Дэлхийн түүхийн төгсгөл” УБ. 2006.
6. НҮБ-ийн Хүний хөгжлийн тайлан илтгэлүүд 2010-2013 он

<sup>15</sup> <http://bolormaa.niitelch.mn/content/5198.shtml> Бүтэн биений шинжилгээ” гэдэг нь... нийтлэл. Л. Болормаа